



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 7/03

Мөрөн сум


Тендерийн баримт бичгийн өгөгдлийн  
хүснэгт, гэрээний маягт, нөхцлийг бэлтэх  
загвар батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгүүд, аймгийн Засаг даргын Тамгын газрын 2018 оны А/68 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар ажил нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгох Тендерийн баримт бичиг бэлтгэх загвар, аргачлалыг нэгдүгээр, нээлттэй тендер шалгаруулалтын аргаар бараа нийлүүлэгчийг сонгох тендерийн баримт бичиг бэлтгэх загвар, аргачлалыг хоёрдугаар, харьцуулалтын аргаар ажил нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгох тендерийн баримт бичиг бэлтгэх загвар, аргачлалыг гуравдугаар, харьцуулалтын аргаар бараа нийлүүлэгчийг сонгох тендерийн баримт бичиг бэлтгэх загвар, аргачлалыг дөрөвдүгээр, зөвлөх үйлчилгээ худалдан авах тендерийн баримт бичиг бэлтгэх загвар, аргачлалыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай .

2. Захиалагчийн тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгт, гэрээний маягт, гэрээний тусгай нөхцөлийг Сангийн сайдын баталсан жишиг тендерийн баримт бичигт үндэслэн бэлтгэх загвар, аргачлалыг мөрдөн ажиллахыг үнэлгээний хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга (Б.Болд)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.ДОЛЖИНСОРОГДОГ



d:/tushaal

Орон нутгийн өмчийн газрын даргын 2022  
оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн а/...  
дугаар тушаалын 5 дугаар хавсралт

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

№:

ТӨСЛИЙН НЭР:


ТӨСЛИЙН ДУГААР:

ТӨСЛИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР:

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭР:

ЗАХИАЛАГЧИЙН НЭР:

БАТЛАВ: АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА



Б.ДОЛЖИНСОРОГДОГ

ХЯНАСАН: АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
АЛБАНЫ ДАРГА Б.БОЛД

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. *[Захиалагч байгууллагын нэр]* нь *[төслийн/үйлчилгээний нэр]*-ийг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь *[товч танилцуулга, байгууллага, хэрэгжүүлэх хугацаа гэх мэт]* болно.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг (нийтлэл, ижил төрлийн ажлын туршлага, ажиллах боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл гэх мэт) ирүүлнэ. Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.
4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг *[огноо]*-ний *[цагийн]* хооронд авч болох бөгөөд мэдүүлгээ дор дурдсан хаягаар *[мэдүүлэг хүлээн авах эцсийн огноо]*-ний дотор ирүүлнэ үү.

*[Захиалагчийн тодорхой хаяг  
(өрөөний дугаар, харилцах албан тушаалтны нэр, утас/факс)]*

### ТЕНДЕРИЙН ӨГӨГДӨЛИЙН ХҮСНЭГТ (ТӨХ)

ТӨХ-ын холбогдох заалт	Ерөнхий зүйл
ТӨЗ 1.1	<p><b>Захиалагч:</b> Аймгийн Засаг даргын Тамгын газар, Орон нутгийн өмчийн газар</p> <p><b>Үнэлгээний арга:</b></p>
ТӨЗ 1.2	<b>Техникийн болон санхүүгийн саналаа нэгэн зэрэг ирүүлэх</b>
ТӨЗ 1.3	<b>Зөвлөх үйлчилгээ үе шатад хуваагдана:</b> <i>[“тийм” эсхүл “үгүй” гэсний аль тохирохыг сонгож үлдээ. Хэрэв тийм бол үе шатыг заа]</i>
ТӨЗ 1.4.	<p><b>Санал ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулагдана:</b> <i>[тийм эсхүл үгүй аль тохирохыг сонгох. Хэрэв тийм бол уулзалт болох газар, огноо, цагийг заа]</i></p> <p><b>Мөн захиалагчийн ажилтны нэр, хаяг болон утасны дугаар:</b></p>
	<b>Тусгай зөвшөөрөл:</b>

ТӨЗ 1.5	Захиалагчийн оролцоо, үзүүлэх дэмжлэг, байр, тоног төхөөрөмж:												
ТӨЗ 1.7.2	Зөвлөх үйлчилгээг цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэх шаардлагатай: “тийм” эсвэл “үгүй” [хэрэв тийм бол ажлын даалгаварт цаашид гүйцэтгэх ажлын хэмжээ, онцлог, хугацаа болон энэ мэдээллийг үнэлгээнд хэрхэн харгалзахыг зааж өгнө.]												
ТӨЗ 2.1	Санал хүлээн авах хугацаанаас ___ хоногийн өмнө ирсэн тодруулгад харну өгнө. [тодруулга хүлээн авах хаягыг оруул.]												
ТӨЗ 3.3	Тендерийн баталгааны үнийн дүн: <i>[Төсөвт өртгийн 1-2 хувиар баталгааны хэмжээг тогтоож үнийн дүнг оруулна.]</i>												
ТӨЗ 3.5	Хүчинтэй байх хугацаа: ..... он ..... сар ..... өдөр <i>[Тендерийн баталгааны хүчинтэй байх хугацааг он, сар, өдрөөр тогтооно.]</i>												
ТӨЗ 4.1	Саналыг ..... хэл (хэлүүд)-ээр ирүүлнэ.												
ТӨЗ 4.4	Хураангуй жагсаалтад орсон компани мөн жагсаалтад орсон бусад компанитай хамтран ажиллаж болно: “тийм” эсхүл “үгүй”												
ТӨЗ 4.4.1	Зөвлөхийн үйлчилгээг гүйцэтгэхэд ___ хүн-сар мэргэжлийн үйлчилгээ шаардагдана.												
ТӨЗ 4.4.2	Чанарын үнэлгээний аргыг хэрэглэх бол тухайн зөвлөх үйлчилгээний төсөвт өртөг:												
ТӨЗ 4.4.4	<p>Зөвлөхийн санал болгох ажилтанд шаардагдах туршлагын доод төвшин: <i>[албан тушаал, хэдэн жил ажилласан байх, нарийн мэргэшсэн туршлага]:</i></p> <p>Тендерт оролцогч нь дараах хүснэгтэд заасан албан тушаал, үр чадвар, туршлага, мэргэжил бүхий хүний нөөцийг санал болгох үүрэгтэй.</p> <table border="1" data-bbox="371 1619 1358 1765"> <thead> <tr> <th>№</th> <th>Албан тушаал</th> <th>Хүний тоо</th> <th>Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага</th> <th>Мэргэжил</th> <th>Диплом, мэргэжлийн үнэмлэх байгаа эсэх</th> </tr> </thead> <tbody> <tr> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> </tr> </tbody> </table> <p>- Дээрх хүснэгтэд заасан инженер, техникийн ажилтнуудын мэдээллийг маягтын дагуу үнэн зөв гаргаж, ажилтнуудын ажлын туршлагын мэдээллийг хүн тус бүрээр баталгаажуулж ирүүлбэл зохино. Энэхүү төсөл, арга хэмжээнд ажиллуулах ажилтнуудыг томилсон захирлын тушаалын эх хувиас татсан хуулбар болон</p>	№	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага	Мэргэжил	Диплом, мэргэжлийн үнэмлэх байгаа эсэх						
№	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага	Мэргэжил	Диплом, мэргэжлийн үнэмлэх байгаа эсэх								



	<p>инженер, техникийн ажилтнуудын иргэний үнэмлэхийн хуулбарыг ирүүлнэ. Сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлэх шаардлагагүй, “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана. “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/-д инженер, техникийн ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай. Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн бол тендерийн нээлтээс өмнө БШУЯ-ны Мэдээллийн технологи статистикийн хэлтэст хандаж дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ үү. Дээрх бүртгэл хийгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу. Хэрэв гадаад улсын их, дээд сургууль, коллежид боловсрол эзэмшсэн этгээдийг төсөл арга хэмжээнд ажиллуулах тохиолдолд дипломын хуулбарыг тендерт ирүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/ системээс мэдээлэл шалгах заавартай дараах холбоосоор танилцана уу. <a href="https://bit.ly/3J1QmHZ">https://bit.ly/3J1QmHZ</a></li> <li>- Хэрэв инженер, техникийн ажилтнууд нь гэрээгээр ажиллах бол хөлсөөр ажиллах гэрээ, иргэний үнэмлэхийн хуулбарыг ирүүлнэ.</li> <li>- Хөлсөөр ажиллуулах гэрээ нь зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай бөгөөд гэрээний хугацаа, үнийн дүн болон бусад нөхцөлийг тодорхой тусгасан байна.</li> </ul> <p><b>Дээрх инженер, техникийн ажилтнуудын 50 ба түүнээс доошгүй хувь нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байх шаардлагатай бөгөөд нийгмийн даатгалын шимтгэлийг 2021 оны 10, 11, 12 дугаар саруудад тендерт оролцогч тасралтгүй төлсөн болохыг “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан шалгах тул НД-8 маягтаар гаргасан тайланг ирүүлэх шаардлагагүй.</b></p>
ТӨЗ 4.4.6	Зөвлөхийн үйлчилгээний хүрээнд хийгдэх тайланг ..... хэл (хэлүүд)-ээр бэлтгэнэ.
	Хийгдэх ажлын үндсэн хэсэгт сургалт орсон: тийм, үгүй аль нэгийг сонгох [тийм бол холбогдох мэдээллийг бич]
ТӨЗ 4.5	<p>Техникийн санал ирүүлэх хэлбэр нь: [ БХТС эсхүл ХТС аль тохирохыг сонгох] байна.</p> <p>Техникийн саналтай холбоотой бусад нэмэлт мэдээлэл:</p>
ТӨЗ 4.8	<p>Татвар [Зөвлөхийн үйлчилгээг гүйцэтгэхэд төлөх татвар, хураамжийн талаарх мэдээллийг бичнэ]:</p> <p><b>1.Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй байх шаардлагатай.</b></p> <p>Нийгмийн даатгал, татварын тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй, “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> болон “Төрийн мэдээлэл солилцооны ХУР</p>



	<p>систем"-ээр дамжуулан Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана. /Тендерт оролцогчийн ирүүлсэн татвар, нийгмийн даатгалын тодорхойлолтыг үнэлгээнд харгалзан үзэхгүй./</p> <p><b>2. Зөвлөх нь гэрээний төлбөрөөс хууль тогтоомжийн дагуу татвар төлөх бөгөөд татвар хураамжийг үнийн саналдаа заавал тусгана.</b></p>
ТӨЗ 4.9	<b>Зөвлөх санхүүгийн саналыг [валютыг<sup>22</sup> зааж өгнө] илэрхийлнэ.</b>
ТӨЗ 4.10	<b>Санхүүгийн санал нь түүнийг хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 45 хоног буюу [он, сар, өдөр] хүртэл хүчинтэй байна.</b>
ТӨЗ 5.3	<b>Хуулбар хувь ирүүлэх тоо:</b>
ТӨЗ 5.4	<p><b>Санал ирүүлэх хаяг:</b></p> <p><b>Гаднах дугтуйд бичих мэдээлэл:</b></p>
ТӨЗ 5.5	<b>Саналыг 201__ оны __-р сарын __-ны өдрийн __ цаг __минутаас өмнө ирүүлсэн байх ёстой.</b>
ТӨЗ 6.2	<p><b>БХТС-ын Үнэлгээний шалгуур үзүүлэлт, оноо: (ХТС-д хамаарахгүй) <u>Оноо</u></b></p> <p>(1) <b>Зөвлөхийн ажлын даалгаварт заасан ажил, үйлчилгээг гүйцэтгэж байсан тусгайлсан туршлага: [5-10]</b></p> <p><b>1. Энэхүү төслийн төсөвт өртгийн 50 хувьтай тэнцэхүйц гэрээний үнэ бүхий ижил төстэй зөвлөх үйлчилгээг сүүлийн 5 жилийн аль нэг жилд нь ядаж нэг удаа хэрэгжүүлсэн туршлагатай байх.(Нотлох баримт бичиг:Өмнөх үйлчлүүлэгтэй байгуулсан гэрээний хуулбарыг өөрийн тендерт ирүүлнэ)</b></p> <p><b>2.Энэхүү төслийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаатай дүүцэхүйц ижил төстэй зөвлөх үйлчилгээг сүүлийн 5 жилийн аль нэг жилд нь ядаж нэг удаа хэрэгжүүлсэн туршлагатай байх.(Нотлох баримт бичиг:Өмнөх үйлчлүүлэгчийн гэрээ дүгнэсэн акт, зураг төсөл хүлээн авсан актыг тус тус өөрийн тендертээ ирүүлнэ)</b></p>

<sup>22</sup> Валют нь 2-оос дээшгүй байвал зохино.

*[дэд үзүүлэлт]*

- (2) Зөвлөхийн санал болгож буй ажлын хөтөлбөр болон аргачлал нь ажлын даалгаврын шаардлагад нийцсэн байдал

*[дэд үзүүлэлт]*

*[дэд үзүүлэлт]*

*[дэд үзүүлэлт]*

*[20-40]*

- (3) Зөвлөхийн үйлчилгээг гүйцэтгэх голлох мэргэжилтнүүдийн чадвар болон туршлага

1.Төслийг хэрэгжүүлэх голлох мэргэжилтэн, инженер, техникийн ажилтнуудын 50 ба түүнээс доошгүй хувь нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байх шаардлагатай. (ТӨЗ-4.4.4-д заасан баримт бичгийг үндэслэнэ.)

2.Уг төслийг хэрэгжүүлэхээр санал болгож буй голлох мэргэжилтнүүд нь энэхүү төслийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаатай дүүцэхүйц ижил төстэй зөвлөх үйлчилгээг сүүлийн 5 жилийн аль нэг жилд нь ядаж нэг удаа хариуцан ажилласан туршлагатай байх.

*[15-30]*

3.*[дэд үзүүлэлт]*

Дээрх 3 шалгуур үзүүлэлт бүрийн дагуу өгөх оноо нь дараахь 3 дэд үзүүлэлтийн эзлэх хувийн жинд нийцсэн байх ёстой:

- (1) Ерөнхий чадвар
- (2) Тухайн зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх чадвар
- (3) Хэлний болон бүс нутгийн мэдлэг, туршлага

*Нийт хувийн жин:*

- (4) Мэдлэг дамжуулах хөтөлбөрийн тохиромжит байдал (сургалт)

*[дэд үзүүлэлт]*

*[дэд үзүүлэлт]*

*[дэд үзүүлэлт]*

- (5) Дотоодын мэргэжилтний оролцоо (гадаадын болон дотоодын зөвлөхийн санал болгосон голлох мэргэжилтнүүдийн иргэншлийн байдалд тулгуурлана: 10 онооноос үл хэтэрнэ.)

	<i>[дэд үзүүлэлт]</i>	
	<i>[дэд үзүүлэлт]</i>	<i>ы[20-30%]</i>
	<i>[дэд үзүүлэлт]</i>	<i>[40-50%]</i>
	<u>Нийт оноо:</u>	<i>[10-20%]</i>
Авбал зохих техникийн доод оноо: 70		100%
		<i>[0-10]</i>
		<i>[0-10]</i>
		100
<b>ХТС-ын Үнэлгээний шалгуур үзүүлэлт, оноо:</b>		<u>Оноо</u>
1) Зөвлөхийн санал болгож буй ажлын хөтөлбөр болон аргачлал нь ажлын даалгаврын шаардлагад нийцсэн байдал		<i>[20-30]</i>
	<i>[дэд үзүүлэлт]</i>	
	<i>[дэд үзүүлэлт]</i>	
	<i>[дэд үзүүлэлт]</i>	
2) Зөвлөхийн ажлын даалгаварт заасан ажил, үйлчилгээг гүйцэтгэж байсан тусгайлсан туршлага:		<i>[15-40]</i>
	<i>[дэд үзүүлэлт]</i>	
	<i>[ дэд үзүүлэлт ]</i>	



	<p>3) Зөвлөхийн үйлчилгээг гүйцэтгэх голлох мэргэжилтнүүдийн чадвар болон туршлага <span style="float: right;">[15-30]</span></p> <p style="padding-left: 40px;"><i>[дэд үзүүлэлт]</i></p> <p style="padding-left: 40px;"><i>[дэд үзүүлэлт]</i></p> <p style="padding-left: 40px;"><i>[дэд үзүүлэлт]</i></p> <p>Дээрх шалгуур үзүүлэлт бүрийн дагуу өгөх оноо нь дараахь дэд үзүүлэлтийн эзлэх хувийн жинд нийцсэн байх ёстой:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Ерөнхий чадвар</li> <li>2. Тухайн зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх чадвар</li> <li>3. Хэлний болон бүс нутгийн мэдлэг, туршлага</li> </ol> <p style="text-align: right;"><u>Нийт хувийн эжин:</u> <span style="float: right;">[20-30%]</span></p> <p style="text-align: right;"><span style="float: right;">[50-60%]</span></p> <p style="text-align: right;"><span style="float: right;">[10-20%]</span></p> <p>Авбал зохих техникийн доод оноо: 70 <span style="float: right;">100%</span></p>
ТӨЗ 6.6	<p>Үнийг хөрвүүлэх валют: _____</p> <p>Монголбанкны албан ёсны ханш: _____</p> <p>Огноо: _____</p>
ТӨЗ 6.7	<p>Санхүүгийн саналын оноог дараах томъёогоор тооцоолж гаргана:</p> <p style="text-align: center;"><math>[Sf=100 \times Fm/F</math></p> <p style="text-align: center;"><i>Sf - санхүүгийн саналын оноо,</i></p> <p style="text-align: center;"><i>Fm - хамгийн бага үнэ бүхий санхүүгийн санал,</i></p> <p style="text-align: center;"><i>F - тухайн зөвлөхийн санал болгосон үнэ]</i></p> <hr/> <p>Техникийн болон санхүүгийн саналын хувийн жин (T+P=1)<sup>23</sup>:</p>

<sup>23</sup> Олон улсын практикт ихэнх тохиолдолд техникийн саналд 0.7-0.9, харин санхүүгийн саналд 0.1-0.3-ын хооронд хувийн жин өгдөг.

	<p>T= .....</p> <p>P= .....</p>
ТӨЗ 7.1	Хэлэлцээр хийх газрын хаяг:
ТӨЗ 8.2	Зөвлөх үйлчилгээг [он, сар, өдөр]-ны өдөр [байриил]-д эхлүүлнэ:
ТӨЗ 9.1	<p><i>[Дараах сонголтуудаас аль тохирохыг үлдээ]</i></p> <p>(а) Гүйцэтгэлийн баталгаа шаардахгүй;</p> <p>эсвэл</p> <p>(б) Тохирох маягтын дагуу Гүйцэтгэлийн баталгааг гаргуулж гэрээнд гарын үсэг зурахаас өмнө захиалагчид ирүүлэх шаардлагатай. Гүйцэтгэлийн баталгааны хэмжээ буюу мөнгөн дүн нь гэрээний үнийн дүнгийн 5 хувиас багагүй байна.</p>

БАТЛАВ.

ЗӨВШӨӨРСӨН<sup>24</sup>.

ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧ:

*[Санхүүжилтийн эрхийг нээх байгууллага, удирдах албан тушаалтан]*

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

.....

(Гарын үсэг)

\_\_\_\_\_

(Гарын үсэг)

\_\_\_\_\_

(Гарын үсэг)

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

(Албан тушаал)

\_\_\_\_\_

(Албан тушаал)

\_\_\_\_\_

(Албан тушаал)

(Тамга)

(Тамга)

(Тамга)

<sup>24</sup> Хэрэв санхүүжилтийн эрхийг нээх байгууллага, захиалагч хоёр нэг этгээд бол энэ хэсгийг хасна.



ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар № [гэрээний дугаар]

хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [зөвлөхийн нэр] (цаашид “зөвлөх” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав. Үүнд:

<b>1. Үйлчилгээ</b>	<p>1.1. Зөвлөх нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт 1-д тодорхойлсон “Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ”-нд заасан ажил үйлчилгээг (цаашид “үйлчилгээ” гэх) үзүүлэх үүрэгтэй.</p> <p>1.2. Зөвлөх нь үйлчилгээг үзүүлэхдээ Хавсралт 2-т тодорхойлсон “Зөвлөхийн ажиллах хүчний жагсаалт”-д заасан мэргэжилтнүүдийг ажиллуулах үүрэгтэй.</p> <p>1.3. Зөвлөх нь Хавсралт 3-т тодорхойлсон “Зөвлөхийн тайлан гаргах хуваарь”-т заасан маягтаар, түүнд товлосон хугацаанд тайлангууд гаргаж захиалагчид ирүүлнэ.</p> <p>1.4. Энэхүү гэрээ нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийн хамт хүчин төгөлдөр байх бөгөөд захиалагч болон зөвлөх нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан үүргийг заавал хэрэгжүүлж мөрдөнө.</p>
<b>2. Хугацаа</b>	<p>2.1. Зөвлөх нь үйлчилгээг [эхлэх өдрийг бичнэ]-нээс [дуусах хугацааг бичнэ]-ий хооронд, эсхүл талуудын бичгээр харилцан тохиролцсон хугацаанд гүйцэтгэнэ.</p>
<b>3. Төлбөр</b>	<p>3.1. <u>Төлбөрийн дээд хэмжээ.</u></p> <p>Захиалагч нь зөвлөхөд Хавсралт 1-ийн дагуу үзүүлсэн үйлчилгээний төлбөрт төлөх дээд хэмжээ нь [дүн, валютыг бичнэ] болно. Энэ дүнд зөвлөхийн бүх зардал, ашиг, мөн түүнчлэн зөвлөхөд ногдож болох аливаа татвар, хураамж орсон болно.</p> <p>3.2. <u>Төлбөрийн хуваарь.</u></p> <p>Төлбөрийг доорх хуваарийн дагуу хийнэ:<sup>25</sup> Гэрээний үнийн дүнгийн 40 хувьтай тэнцэх дүнг дунд хугацааны тайлан, мэргэжлийн байгууллагаар хянагдсан зураг төсөл, өртгийн төсөв, техникийн тодорхойлолт, ажлын гүйцэтгэл ирүүлсний дараа төлж болно.</p> <p>(б) Гэрээний үнийн дүнгийн 60 хувьтай тэнцэх дүнг баталгаажсан эцсийн тайлан, батлагдсан зураг төсөл, өртгийн төсөв, материалын техникийн тодорхойлолт, ирүүлсний дараа төлж болно. Эсхүл баталгаажсан зураг төсөл, өртгийн төсөв, эцсийн тайлан, материалын техникийн</p>

<sup>25</sup> Хавсралт 3-т тодорхойлсон үйлчилгээний үр дүнг харгалзан өөрчлөнө.



	<p>тодорхойлолт болон холбогдох баримт бичгийг захиалагчид ирүүлсний дараа захиалагчаас зөвлөхөд олгох гэрээний төлбөрийг 100 хувь олгож болно.</p> <p>(в) Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргасан тохиолдолд түүнийг үндэслэж гэрээний төлбөрийн 50 хүртэл хувийг зөвлөхөд олгож болно.</p> <p>Нийт төлөх дүн: <b>[төлбөрийн дүн, валютыг заах].</b></p> <p>3.3. <u>Төлбөрийн нөхцөл.</u></p> <p>Төлбөрийг 4 дүгээр зүйлд заасан төлбөрийн нэхэмжлэхийн хувь, гэрээ дүгнэсэн акт, зураг төсөл, өртгийн төсөв, гэрээнд заасан бусад баримт бичгийг хүлээн авсан акт, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогоолоор баталсан журманд заасан баримт бичгийг төслийн зохицуулагчид ирүүлснээс хойш 30 хоногийн дотор <b>[валютыг заа]</b>-өөр хийнэ.</p>
4. Төслийн удирдлага	<p>4.1. <u>Төслийн зохицуулагч.</u></p> <p>Захиалагч нь <b>аймгийн ЗДТГ</b>-ийн ХОХБТХ-ийн мэргэжилтэн, аймагийн ерөнхий архитектор .....төслийн зохицуулагчаар томилж байгаа бөгөөд энэхүү зохицуулагч нь гэрээний дагуу хийгдэх үйл ажиллагааг зохицуулах, төлбөрийн нэхэмжлэх, тайлан болон бусад бичиг баримт, эд зүйлсийг хүлээн авч батлах үүргийг хүлээнэ.</p>
	<p>4.2. <u>Тайлан.</u></p> <p>Зөвлөх нь Хавсралт 3-т тодорхойлсон “Зөвлөхийн тайлан гаргах хуваарь”-т заасан тайланг хуваарийн дагуу ирүүлэх бөгөөд энэ нь 3 дугаар зүйлийн дагуу төлбөр хийх үндэслэл болно.</p>
5. Гүйцэтгэлийн чанар	<p>5.1. Зөвлөх нь үйлчилгээг мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд үнэнч шударгаар үзүүлнэ. Энэхүү гэрээний дагуу зөвлөхийн ажиллуулж буй аливаа ажилтан шаардлага хангаагүй гэж захиалагч үзсэн бол зөвлөх уг ажилтныг нэн даруй солино.</p>
6. Нууцлал	<p>6.1. Зөвлөх нь гэрээний хэрэгжилтийн явцад, мөн түүнийг дуусгавар болсноос хойш хоёр жилийн дотор зөвлөхийн үйлчилгээ болон энэ гэрээтэй холбоотой өмчлөлийн болон нууцлах шаардлагатай мэдээллийг, эсхүл захиалагчийн бизнесийн болон үйл ажиллагааны талаар захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авалгүй задруулах эрхгүй.</p>
7. Өмчлөл	<p>7.1. Энэхүү гэрээний дагуу захиалагчид зориулж зөвлөхийн боловсруулсан аливаа судалгаа, тайлан, зураг, график, программ хангамж болон бусад материал, эд зүйл нь захиалагчийн өмч болж үлдэнэ. Зөвлөх нь эдгээр бичиг баримт болон программ хангамжийн<sup>26</sup> хувийг авч болно.</p>
8. Зөвлөх зарим нэг үйл ажиллагаанд оролцохгүй байх	<p>8.1. Зөвлөх, түүний нэгдмэл сонирхолтой аливаа этгээд нь энэ гэрээний хугацаанд болон гэрээ дуусгавар болсноос хойш энэ үйлчилгээнээс үүсэлтэй, эсхүл түүнтэй нягт холбоотой аливаа төслийн бараа, ажил, үйлчилгээ (энэ үйлчилгээ болон түүний үргэлжлэлээс бусад)-ний гүйцэтгэгчээр ажиллах эрхгүй болохыг зөвлөх хүлээн зөвшөөрч байна.</p>

<sup>26</sup> Хэрэв эдгээр бичиг баримт болон программ хангамжийг цаашид хэрэглэхийг хязгаарлах шаардлагатай бол 7 дугаар зүйлийн эцэст нэмж оруулна.



9. Даатгал	9.1. Зөвлөх нь шаардлагатай бүх даатгалыг өөрийн зардлаар хариуцна.
10. Эрх шилжүүлэлт	10.1. Зөвлөх нь захиалагчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бусад этгээдэд шилжүүлэх, эсхүл түүний аливаа хэсгийг туслан гүйцэтгүүлэх гэрээ байгуулах эрхгүй.
11. Гэрээнд мөрдөх хууль ба хэл,	11.1. Энэ гэрээнд Монгол Улсын хуулийг дагаж мөрдөх ба гэрээний хэл нь <i>хэрэглэх хэлийг бич</i> <sup>27</sup> хэл байна.
12. Маргааныг шийдвэрлэх <sup>28</sup>	12.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргаж асуудлыг шийдвэрлүүлнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХӨГЖЛИЙН БОДЛОГО  
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА

ЗӨВЛӨХИЙГ ТӨЛӨӨЛЖ:

-----  
(Гарын үсэг)

<sup>27</sup> Зөвлөхийг сонгох ажиллагаанд гадаадын компаниуд орж байгаа бол хэрэглэх хэл нь англи, франц, эсхүл испани гэх мэт гадаад хэл байж болно.

<sup>28</sup> Гадаадын зөвлөхтэй гэрээ байгуулж байгаа тохиолдолд 12 дугаар зүйлийг “Энэ гэрээнээс үүдсэн болон энэ гэрээтэй холбогдсон, эсхүл түүнийг зөрчсөн, түүнийг дуусгавар болгосон юм уу хүчингүй болсонтой холбогдсон аливаа маргаан, зөрчилдөөн, нэхэмжлэхийг хүчин төгөлдөр үйлчилж буй UNCITRAL-ын арбитрын журмын дагуу шийдвэрлэнэ.” гэсэн заалтаар сольж болно.

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

Гэрээний нэр:

Гэрээний дугаар:

(Хаалтанд байгаа зүйлийг { } сонгон хэрэглэнэ; эцэслэн боловсруулалт хийхэд тэмдэглэлийг хасна)

ГЕН-ийн зүйлийн дугаар	Гэрээний ерөнхий нөхцлийн холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах буюу өөрчлөнө.
{1.1(a)}	Гэрээнд хэрэглэх хууль нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Иргэний хууль,
1.3	Гэрээний баримт бичгүүд нь <i>Монгол</i> хэл дээр байна.
1.4	<p>Захиалагчийн хаяг: Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр.</p> <p>Захиалагч: Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга</p> <p>Харилцах хүн: Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга П.Ариунбат</p> <p>Утас:</p> <p>Факс:</p> <p>Захиалагч: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн аймгийн ерөнхий архитектор</p> <p>Харилцах хүн: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн аймгийн ерөнхий архитектор Г.Бадамсэрээжид</p> <p>Утас:</p> <p>Факс:</p> <p>И-мэйл:</p>



{1.6}	<p>{Төлөөлөх эрх бүхий гишүүн [гишүүний нэрийг оруул]}</p> <p><u>Тэмдэглэл:</u> Зөвлөх нь түншлэл/консорциум/хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдийн холбооноос бүрдэж байгаа тохиолдолд ГТН-ийн 1.5-д байгаа хаягийг энд оруулна. Зөвлөх дангаар оролцож байгаа бол ГТН-ийн энэ зүйлийг бүхэлд нь хасна.</p>
1.7	<p>Итгэмжлэгдсэн төлөөлөгчид:</p> <p>Захиалагчийн: Аймгийн орон нутгийн өмчийн газрын дарга Б.Должинсорогдог</p> <p>Зөвлөхийн:</p>
1.8	<p>Татвар: Зөвлөх нь Монгол Улсын хууль тогтоомжид заасан татвар хураамжийг төлнө.</p>
{2.1}	<p>Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр: [огноог оруул]</p> <p><u>Тэмдэглэл:</u> Талууд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болно.</p>
2.2	<p>Тогтоосон хугацаа: Зөвлөх нь гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ..... хоногт багтаан үйлчилгээг эхлэх ёстой. [хугацааг оруул, жишээлбэл: 30 хоног г.м].</p>
2.3	<p>Тогтоосон хугацаа: Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ..... хоногийн дараагаар энэхүү гэрээний хугацаа дуусгавар болно. [хугацааг оруул, жишээлбэл: 50 хоног г.м].</p>
2.6	<p>Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд захиалагч өөрийн санаачлагаар гэрээг цуцлах эрхтэй.</p> <p>а) Зөвлөх гэрээний дагуу хүлээсэн үүргээ зөрчсөн талаарх мэдэгдлийг хүлээн авсны дараагаар 30 хоног, эсхүл захиалагчийн бичгээр зөвшөөрөн сунгасан хугацаанд багтаан мэдэгдэл дурдсан зөрчлийг арилган үүргийн гүйцэтгэлийг хангаагүй;</p> <p>б) Зөвлөх (эсхүл түншлэлийн аль нэг гишүүн) төлбөрийн чадваргүй болсон, эсхүл дампуурсан, эсхүл дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, эсхүл сайн дураараа буюу албадан журмын дагуу татан буугдаж байгаа;</p> <p>в) Зөвлөх нь тендерт оролцох буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгал, залилан мэхлэх үйлдэлд холбогдсон байж болох хангалттай үндэслэл захиалагчид байгаа;</p> <p>г) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Зөвлөх нь 20-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон;</p> <p>д) Зөвлөх нь захиалагчийн баталсан зураг, төслийн даалгавар, техникийн нөхцөлд заасан өгөгдөл, шаардлагад нийцэхгүй зураг төсөл боловсруулсан, ажиллах хүчний хуваарьт заасан хүний нөөцийг ажиллуулаагүй, гэрээний аль нэг үүргээ хангалтгүй биелүүлсэн зэрэг</p>

	<p>зөрчлүүдийн аль нэгийг гаргасан тохиолдолд захиалагч өөрийн санаачлага бусад үндэслэлээр гэрээг цуцлахаар шийдвэрлэсэн бол:</p> <p>(е) Зөвлөх ГЕН-ийн 7 зүйл заасны дагуу арбитрийн ажиллагааны үр дүнд гаргасан эцсийн шийдвэрийг биелүүлээгүй:</p>
3.4	<p>Даатгалд зайлшгүй хамруулах зүйл, даатгалын дүнгийн доод хэмжээ нь:</p> <p>(а) Машин механизм, тоног төхөөрөмжийн алдагдал, эсхүл гэмтлийн даатгалд зөвлөхийн доод хэмжээ нь [мөнгөн дүн] байна.</p> <p>(б) Гуравдагч этгээдийн хариуцлагын даатгалд зөвлөхийн төлөх хэмжээ нь [мөнгөн дүн] байна.</p> <p>(в) Мэргэжлийн хариуцлагын даатгалд зөвлөхийн төлөх хэмжээ нь [мөнгөн дүн] байна.</p> <p>(г) Гэнэтийн ослын, амь нас, эрүүл мэндийн хувьд гэрээнд хэрэглэх хуулийн дагуу ажил олгогчийн хүлээх хариуцлагын даатгалд зөвлөхийн төлөх хэмжээ нь [мөнгөн дүн] байна.</p> <p><i>Тэмдэглэл: Энд хэрэглэх шаардлагатай гэж үзсэн даатгалын заалтыг нэмэх эсхүл хэрэглэхгүй заалтыг хасна.</i></p>
{3.5 (в)}	<p>Бусад үйл ажиллагаа: Зөвлөх нь өөрийн боловсруулсан зураг төсвийг дараах байгууллага, албан тушаалтнуудад хандан хянуулж, баталгаажуулсан байна. Үүнд:</p> <p>-Барилга байгууламжийн угсралтын ажлын эскиз зургыг аймгийн ерөнхий архитектор батална.</p> <p>-Барилгын угсралтын ажил, засвар, шинэчлэл, өргөтгөлийн ажлын зураг төслийг аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар болон захиалагчийн холбогдох албан тушаалтнууд хянаж баталгаажуулна.</p> <p>-Барилга байгууламжийн угсралтын болон өргөтгөл, шинэчлэл, засварын ажлын өртгийн төсөв, зураг төслийн тайлбар, материалын техникийн тодорхойлолт, зөвлөх үйлчилгээний тайланг тус тус захиалагчаар батлуулна.</p> <p>-Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт заасан зураг төсөл, өртгийн төсөвт магадлал хийлгэх бөгөөд Барилгын хөгжлийн төв Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт хандан магадлалын дүгнэлт гаргуулсан байна.</p> <p>-Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 хэсэгт хамаарахгүй зураг төсөл, өртгийн төсөвийг захиалагч хянаж баталсан байна.</p>



	<p>-Зөвлөх нь баталгаажсан зураг төсөл эх хувиар 1, хуулбар хувиар 2, баталгаажсан өртгийн төсөв эх хувиар 1, хуулбар хувиар 2, баталгаажсан матариалын техникийн тодорхойлолт, тайлбар бичиглэл эх хувиар тус бүр 1, хуулбар хувиар 2 хувийг тус тус захиалагчийн томилсон ажлын хэсэгт хүлээлгэн өгч, захиалагчтай байгуулсан зөвлөх үйлчилгээний гэрээг дүгнүүлсэн байна.</p>
{5.1}	<p><i>Тэмдэглэл:</i> Барилга байгууламжийн зураг төсөл, өртгийн төсвийг улсын магадлалд оруулах тохиолдолд зураг төсөл өртгийн төсөв, барилгын ажилд ашиглах материалын техникийн тодорхойлолтыг захиалагч хянаж, магадлалд оруулах зөвшөөрлийг зөвлөхөд олгоно.</p>
6.2(б)	<p>Төгрөгөөр хийх төлбөрийн дээд хэмжээ: <i>[хэмжээг тоо болон үсгээр оруул]</i></p>
6.4	<p>Төлбөр хийх данснууд:</p> <p>Төгрөгийн хувьд: <i>[дансны нэр, дугаарыг оруул].</i></p> <p>Төлбөрийг дараахь хуваарийн дагуу төлнө.</p> <p>(а) Гэрээний үнийн дүнгийн 40 хувьтай тэнцэх дүнг дунд хугацааны тайлан, мэргэжлийн байгууллагаар хянагдсан зураг төсөл, өртгийн төсөв, техникийн тодорхойлолт, ажлын гүйцэтгэл ирүүлсний дараа төлж болно.</p> <p>(б) Гэрээний үнийн дүнгийн 60 хувьтай тэнцэх дүнг баталгаажсан эцсийн тайлан, батлагдсан зураг төсөл, өртгийн төсөв, материалын техникийн тодорхойлолт, ирүүлсний дараа төлж болно. Эсхүл баталгаажсан зураг төсөл, өртгийн төсөв, эцсийн тайлан, материалын техникийн тодорхойлолт болон холбогдох баримт бичгийг ирүүлсний дараа захиалагчаас зөвлөхөд олгох гэрээний төлбөрийг 100 хувь олгож болно.</p> <p>(в) Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргасан тохиолдолд түүнийг үндэслэж гэрээний төлбөрийн 50 хүртэл хувийг зөвлөхөд олгож болно.</p> <p><i>Тэмдэглэл:</i> Энэхүү зүйлийг тендер зарлахын өмнө гэрээ бүрийн шинж онцлогт тохируулан боловсруулах үүргийг үнэлгээний хороо харицана.</p>
6.5	<p>Хүүгийн хувь хэмжээ: Зөвлөх нь зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээг дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хойш дуусгасан тохиолдолд хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх алдангийг<sup>7</sup> захиалагчид төлөх ба алдангийн нийт хэмжээ гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй. Энэхүү алданги нь үе шатны хуваарьт заасан ажил гүйцэтгэх хугацаанд нэгэн адил хамаарна. Зөвлөхөд олгох санхүүжилтийн дүнг алдангийн хэмжээгээр бууруулан олгоно.</p> <p>Зөвлөхөд захиалагчаас олгох санхүүжилтийг хугацаа хоцроосон тохиолдолд санхүүжилт хоцроосон хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчаас гүйцэтгэгчид төлөх бөгөөд алдангийн нийт хэмжээ гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй. Зөвлөхөд алданги төлөх тохиолдолд гэрээний төлбөрийг алдангийн хэмжээгээр нэмэгдүүлнэ. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүжилт саатснаас үүсэх алдангийг захиалагч хариуцахгүй.</p>

	<p>Энэхүү гэрээтэй холбоотой дараах баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг байна:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хавсралт №1 үйлчилгээний тодорхойлолт</li> <li>2. Хавсралт №2 - тайлан гаргах хуваарь</li> <li>3. Хавсралт №3 голлох мэргэжилтний болон туслан гүйцэтгэгчийн мэдээлэл</li> <li>4. Хавсралт №4 - гэрээний үнийн задаргаа</li> <li>5. Хавсралт №5 –Захиалагчийн үзүүлэх үйлчилгээ</li> <li>6. Гэрээний ерөнхий нөхцөл</li> <li>7. Гэрээний тусгай нөхцөл</li> <li>8. Шаардлагатай тохиолдолд бол гүйцэтгэлийн баталгаа</li> <li>9. Шаардлагатай тохиолдолд бол урьдчилгаа төлбөрийн баталгаа</li> </ol>
8.2	<p>Гэрээтэй холбоотой үүссэн маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.</p>

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЗӨВЛӨХИЙН ТӨЛӨӨЛЖ:

АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА  
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА